



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.17 № 03/2745
танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240102007 дугаартай “Зорчигчийн үйлчилгээний нэг удаагийн хуванцар бараа бүтээгдэхүүн” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1 болон 3 дугаар багцад оролцсон “Кей Жи Платформ” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох материалд үндэслэн гомдлын хүрээнд хянан үзлээ.

“Кей Жи Платформ” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грандавто ланд” ХХК-ийн тендерт ирүүлсэн зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт болон түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн талаарх Голомт банкны тодорхойлолт шаардлага хангахгүй байгааг, мөн тус компани нь 2023 онд захиалагчийн зарласан МИАТ/202310108 дугаартай тендер шалгаруулалтад оролцохдоо Стандарт, хэмжил зүйн газрын УБД0001038 дугаартай тохирлын гэрчилгээг хуурамчаар үйлдсэн талаар гомдол гаргасан бөгөөд захиалагч хуулийн 14.5 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ аваагүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Грандавто ланд” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.10 дахь заалтад “энэ хуулийн 56.5-д заасан нөхцөл илэрсэн оролцогчийн талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хянуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу “Грандавто ланд” ХХК нь тендер шалгаруулалтад оролцохдоо хуурамч баримт бичиг ирүүлсэн талаар захиалагчаас мэдээлэл ирүүлээгүй байна.

2. “Грандавто ланд” ХХК-ийн тендерт ирүүлсэн Голомт банкны 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 10/197 тоот санхүүжилт зээл олгох боломжтой тухай тодорхойлолт нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан “...Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө эсхүл авах боломжтой зээлийн хэмжээ нь багц тус бүр дээр батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй байх” шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

9766004622

3. “Грандавто ланд” ХХК-ийн тендерт ирүүлсэн зээлийн мэдээллийн лавлагаанд бичигдсэн регистрийн дугаар нь тус компанийн дугаар биш, компанийн нэр нь бичигдээгүй, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс цахим лавлагаа ирүүлээгүй байх тул тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан “...Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагаа” ирүүлэх шаардлагыг хангахгүй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/799 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг гүдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Кей Жи Платформ” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

A rectangular box containing a handwritten signature in black ink. The signature is stylized and appears to be 'Ж. ГАНБАТ'. The box has a dotted border.

Ж.ГАНБАТ